



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.1, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ үйлчилгээг халдвар хамгааллын заавар, зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэн, дэглэмийг чанд сахин мөрдүүлж, мөн НЗЗ-ны байрууд болон зоогийн газруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/, Үйлчилгээний албаны дарга /М.Алтантуяа/, Байр ашиглалтын албаны дарга /Г.Батзаяа/, Байр хариуцсан менежер нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч дарга /С.Доржсүрэн, Ч.Однасан, Б.Галмандах/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\A тушаал.docx

1150500121

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2020 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн
.../61... дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Коронавируст /Ковит-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төлөвлөх, арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Зохион байгуулалтын үйл ажиллагаа

- 2.1 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллах;
- 2.2 Нэгдмэл удирдлага, зохион байгуулалтад орж, дээд шатны байгууллагын өгсөн заавар, зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллах;
- 2.3 Нөхцөл байдлын талаар болон дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, холбогдох мэдээллийг хэлтэс, албадын дарга, ажилтан, албан хаагч нарт тухай бүр мэдээлэх;
- 2.4 Байгууллага, ажилтан албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, техник хэрэгслээр хангах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сахиулах, ажилтан албан хаагчдын ажил, амралтын хуваарийг зохицуулж эрүүл мэндэд анхаарах;
- 2.5 Байгууллагын өрөө тасалгаа, ажилтан, албан хаагчдын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, хяналт тавьж тайлагнаж ажиллах;
- 2.6 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд сахилга хариуцлагыг өндөржүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, гар утсыг 24 цагаар нээлттэй байлгах;
- 2.7 Холбоо, зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулж, сахилга хариуцлагыг өндөржүүлэн НЗЗ-ны байруудын харуул, хамгаалалтыг чангатгах;
- 2.8 Шаардлагатай тохиолдолд цаг харгалзахгүйгээр дуудагдаж ажиллах;
- 2.9 Байгууллагын бэлэн байдал, тогтвортой ажиллагааг хангаж, хариуцлагатай эргүүл жижүүрийг батлагдсан хуваарийн дагуу биеэр болон утасаар хийж гүйцэтгэх;
- 2.10 Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагын удирдлагад өдөр тутам танилцуулах;

Гурав. Хариуцлага


- 3.1 Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээг зөрчсөн ажилтан, албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллах;

Дөрөв. Үйл ажиллагааны зардал

- 4.1 Коронавируст /Ковит-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээ авах үйл ажиллагааны зардлыг байгууллагаас шийдвэрлэж ажиллах;

1	2	3	4
2.3	Нийслэлийн засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээг халдвар хамгааллын заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэх, дэглэмийг чанд мөрдүүлэх	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд
Гурав. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх чиглэлээр:			
3.1	Хариуцаж буй байруудын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулах, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг онцгойлон анхаарч ажиллах	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд
3.2	Гадна талбайн 50 метр хүртэлх орчинд хийх цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх, халтиргаа, гулгаанаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд
3.3	Зоогийн газрын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтэд онцгой анхаарч гарал үүслийн бичиг баримтыг шалгах, зоогийн газрын цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, халдваргүйтгэлд хяналт тавих, ажилчдын эрүүл аюулгүй байдалд анхаарах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Зоогийн газрын менежер
Дөрөв. Бэлэн байдлыг хангаж ажиллах чиглэлээр			
4.1	Газрын даргын тушаалаар баталсан байгууллагын гамшгийн төлөвлөгөөний дагуу ажилтан, албан хаагчдыг гамшгаас хамгаалах, зарлан мэдээлэх схемээр бэлэн байдлыг хангуулах	Тухай бүр	Байр ашиглалтын албаны дарга
4.2	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дээд шатны байгууллага, Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу тухай бүр арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллах	Тухай бүр	Орлогч дарга нар Хэлтсийн дарга Үйлчилгээний албаны дарга Байр ашиглалтын албаны дарга
4.3	Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааг тухай бүр байгууллагын ажилтан, албан хаагчдын нэгдсэн группд байршуулах	Тухай бүр	Байр ашиглалтын албаны дарга Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд
4.4	Байгууллага бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажилтан, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, техник хэрэгслээр хангах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сахиулж, ажиллах	Тухай бүр	Орлогч дарга нар Ерөнхий нягтлан бодогч

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын
 даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн
 ...А/61... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



**БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ҮЕД КОРОНАВИРУСТ /КОВИД-19/ ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ
 ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4
Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:			
1.1	Дээд шатны байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, шийдвэр гаргаж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах	Тухай бүр	Орлогч дарга нар Хэлтсийн дарга Үйлчилгээний албаны дарга Байр ашиглалтын албаны дарга
1.2	Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, ариутгалын бодис хэрэглэлийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах	Тухай бүр	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч
1.3	Төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 7 хоног бүрээр гаргах, тухай бүр нэгтгэж удирдлагад танилцуулах	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд Дотоод ажил, сургал хариуцсан ажилтан
Хоёр. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:			
2.1	Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг нийслэлийн засаг захиргааны байруудаар нэвтрүүлэхдээ биеийн халууныг хэмжих, бичиг баримтыг шалгах, бүртгэл, тэмдэглэл хөтлөх, халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахин нэвтрүүлэх ажлыг зохион байгуулалтад оруулах, хяналт тавих	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд
2.2	Нийслэлийн засаг захиргааны байруудад ажиллаж буй байрны жижүүр, цагдаа, харуул хамгаалалтын ажилтнуудын ажлын чиг үүргийг өндөржүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх	Тухай бүр	Үйлчилгээний албаны дарга Байр хариуцсан менежерүүд